



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/210.

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.а, 29.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн гуравдугаар хуралдааны 3/03 дугаар төсөв батлах тухай тогтоолын 4.28 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд хотын нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, зам, гэрлэн дохио шинээр хийх, аялал жуулчлалын вэб сайт, мэдээллийн төв байгуулахад зориулан 444.8 сая /дөрвөн зуун дөчин дөрвөн сая найман зуун мянга/ төгрөгийг хавсралтаар батлан, зарцуулсугай.


2. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу шуурхай зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Батсүх/ нарт үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний зардлыг Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.28-д тусгагдсан "Аймаг байгуулагдсаны 90 жилийн ой, Ардын хувьсгалын 100 жилийн ой угтсан бүтээлч ажил, тохижилт, засвар үйлчилгээ, бүтээн байгуулалт, төсөл арга хэмжээний зардал"-аас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

4. Төсөл арга хэмжээний захиалагчийн техникийн хяналт хийж тайлагнахыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Жаргалант сумын Засаг дарга /Ц.Цогтбаяр/ нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
04 дүгээр сарын 26-ны өдрийн
210 дугаар захирамжийн хавсралт

ХОВД ХОТЫН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛБАЙН ТОХИЖИЛТ,
ЗАМ, ГЭРЛЭН ДОХИО ШИНЭЭР ХИЙХ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ДЭМЖИХ
ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ЖАГСААЛТ

д/д	Төсөл арга хэмжээ нэр	Төсөв өртөг /сая.төг/	Санхүү- жих дүн
1. Хөрөнгө оруулалтын нийт дүн		444.8	444.8
1.1. Авто болон явган зам засвар, Гэрлэн дохио, тохижилт		238.8	238.8
1	Шүүхийн уулзварыг хатуу хучилттай авто замтай холбох 0.068 км	40.0	40.0
2	Монгол банкны уулзварыг хатуу хучилттай авто замтай холбох 0.086 км	49.8	49.8
3	Буурлуудын 4-н замын уулзварын гэрлэн дохио	35.0	35.0
4	Тоглоомтой гудамжны 4-н замын уулзварын гэрлэн дохио	35.0	35.0
5	Тарвастай 4-н замын уулзварын гэрлэн дохио	35.0	35.0
6	Арван мянгат, нисэх чиглэлийн авто замын 4-н замын уулзварын гэрлэн дохио	35.0	35.0
7	Авто зам, явган замын засвар, хайс хашлаганы засвар	9.0	9.0
1.2.Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, засвар		179.0	179.0
8	Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэн дотор "khovd-city" биет үсгэн хаяг хийх	29.0	29.0
9	Зэвсэгт хүчний 123-р ангийн бательоны байр засвар, тохижилт	80.0	80.0
10	Аялал жуулчлалын веб сайт, мэдээллийн төв байгуулах	40.0	40.0
11	Хуучин 1-12 айлын дээврийн хачиг цэвэрлэх, засвар хийх	10.0	10.0
12	Хуучин 2-12 айлын дээврийн хачиг цэвэрлэх, засвар хийх	10.0	10.0
13	Хүүхдийн ордны урьд талбайн тохижилт	10.0	10.0
1.3.Нийтийн эзэмшлийн талбайн цэцэгжүүлэлт		27.0	27.0
14	Театрын ар талын цэцгийн мандал	9.0	9.0
15	Нутгийн удирдлагын ордны дээд талын цэцгийн мандлууд	9.0	9.0
16	Ард Аюушийн талбайн 4-н цэцгийн мандал	9.0	9.0